



МОНГОЛ УЛС  
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 0/307

Баруун-Урт сум

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5, 12 дугаар зүйлийн 12.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Эрдэнэцагаан сумын 2-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Н.Чинбат захиралтай “Баянхошуу говь” ХХК-ний “Алтан босго” хүнсний дэлгүүр, Эрдэнэцагаан сумын 8-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Наранцэцэг захиралтай “Мөнхөд орших гал” ХХК-ний “Таван эрдэнэ” хүнсний дэлгүүр, Баруун-Урт сумын 1-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Ц.Хүрэлбат захиралтай “Чулуут нуруу” ХХК-ний “Исгэрээ” хүнсний дэлгүүр, Дарьганга сумын 4-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Оюунтуяа захиралтай “Дарьганга баян бадрах” ХХК-ний “Баян бадрах” хүнсний дэлгүүр, Баруун-Урт сумын 7-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Д.Баяраа захиралтай “Улаан дэл -Их уул” ХХК-ний S-Mart минимаркет, Баруун-Урт сумын 6-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Ж.Болор-Эрдэнэ захиралтай “Минж хонгор” ХХК-ний “Баясах” Хүнсний дэлгүүр, Дарьганга сумын 4-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Г.Энхжаргал захиралтай “Дарьганга дээд” ХХК-ний “Дээжис” хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах, Түмэнцогт сумын 4-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Ц.Мягмар захиралтай “Өсөхбаяр Эрхэт ”ЗГБХН-ийн “А3” карооке, пабын согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай сунгаж, Баруун-Урт сумын 1-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Ж.Сүрэнхүү захиралтай “Өнө энхжин” ХХК-ний “Саятан” минимаркетийн согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай олгосугай.

0000631

2. Тусгай зөвшөөрөл сунгагдсан аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Х.Энхцэцэг/, Цагдаагийн газар /хурандаа Д.Батчулуун/, Мэргэжлийн хяналтын газар /О.Балжинням/, Стандарт хэмжил зүйн хэлтэс /Д.Эрдэнэбат/, холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг мөрдөн ажиллахыг аж ахуй нэгжүүдийн захирлуудад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ